# УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2023/159/НА-СТА-ТШЗ


| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаангом хот<br>2023 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит" ХХК<br>аудитор: Я.Тунгалаг<br>Утас: 99459698 Цахим хаяг: anu_gantun@yahoo.com |
|---|---|


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.24 № УВА-2023/159/НА-СТА-ТИЗ
танай ______ -ны № ______ -т

ХЯРГАС СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Х.ЦОГТБАЯР
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсрол шинжлэх ухааны яамнаас үнэ төлбөргүй 11,600.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 8,080.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 6,925.7 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө, төсвийн хөрөнгөөр 43,152.0 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж худалдаж авсан байна.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200200449

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

АГУУЛГА


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Асуудлыг онцолсон хэсэг

Аудитын гол асуудал

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

4.2 Материаллаг байдал

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нийцлийн аудит |

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **199,806,920.89** | **242,343,522.34** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 27,091,265.57 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 27,091,265.57 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 27,091,265.57 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 27,091,265.57 |
| **33** | **АВЛАГА** | 2,081,352.16 | 327,486.00 |
| **335** | **Бусад авлага** | 2,081,352.16 | 327,486.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 2,081,352.16 | 327,486.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 197,725,568.73 | 214,924,770.77 |
| **354** | **Хангамжийн материал** | 197,725,568.73 | 214,924,770.77 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,869,250.00 | 6,154,750.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 184,462,175.44 | 199,106,931.48 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 595,044.00 | 2,280,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,799,099.29 | 7,383,089.29 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,293,275,549.43** | **1,253,514,619.87** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,293,275,549.43 | 1,253,514,619.87 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,260,651,549.43 | 1,220,890,619.87 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,077,342,030.00 | 1,077,342,030.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -114,565,692.68 | -160,554,857.12 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 39,400,000.00 | 39,400,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -9,302,777.74 | -15,869,444.38 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 262,451,582.53 | 317,203,582.53 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -179,187,894.14 | -203,955,902.50 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 159,824,772.00 | 167,904,772.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -109,207,298.45 | -121,485,127.14 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 138,631,694.00 | 145,557,431.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -43,837,171.89 | -63,754,170.82 |
| 39217 | Ном | 39,102,305.80 | 39,102,305.80 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 32,624,000.00 | 32,624,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 32,624,000.00 | 32,624,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,493,082,470.32** | **1,495,858,142.21** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,493,082,470.32** | **1,495,858,142.21** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,493,082,470.32 | 1,495,858,142.21 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 448,356,451.20 | 448,356,451.20 |
| 51101 | Өмч: - төрийн | 448,356,451.20 | 448,356,451.20 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 152,057,315.59 | 154,832,987.48 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 152,057,315.59 | 152,057,315.59 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 2,775,671.89 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 892,668,703.53 | 892,668,703.53 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,493,082,470.32** | **1,495,858,142.21** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,182,005,127.44** | **1,401,447,693.54** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,821,578.44** | **40,713,993.54** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,821,578.44 | 40,713,993.54 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,821,578.44 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,821,578.44 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **149,908,149.00** | **1,360,733,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 1,164,658,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 1,164,658,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,029,275,400.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,658,949.00 | 2,812,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,158,949.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,500,000.00 | 2,812,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 143,249,200.00 | 193,261,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 143,249,200.00 | 193,261,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,252,400,981.04** | **1,398,672,021.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,252,400,981.04** | **1,398,672,021.65** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,213,911,244.60 | 1,344,264,793.82 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 798,315,824.40 | 891,586,083.17 |
| 210101 | Үндсэн цалин | 508,709,088.40 | 614,031,625.28 |
| 210102 | Нэмэгдэл | 218,782,246.00 | 235,342,902.28 |
| 210104 | Урамшуулал | 61,151,696.00 | 42,211,555.61 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 9,672,794.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 102,230,314.25 | 112,778,974.59 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 71,228,286.25 | 80,023,666.77 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,981,610.00 | 7,660,679.43 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,385,286.00 | 7,117,436.87 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,514,740.00 | 1,639,584.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,120,392.00 | 16,337,606.94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 136,475,437.00 | 138,017,732.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,694,756.00 | 5,613,691.00 |
| 210302 | Түлш, халаалт | 132,480,681.00 | 132,404,041.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,531,824.00 | 11,714,300.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,231,749.00 | 474,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,854,575.00 | 9,598,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 511,000.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 130,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,736,500.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,068,000.00 | 1,642,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 39,453,370.00 | 48,220,200.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 349,800.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 36,752,770.00 | 48,220,200.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,350,800.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,352,000.00 | 3,686,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,352,000.00 | 3,686,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 928,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 928,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,955,200.00 | 9,213,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,000.00 | 2,812,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,052,000.00 | 6,401,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 115,669,274.95 | 129,047,604.06 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 10,359,237.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,081,200.00 | 9,169,700.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 111,588,074.95 | 109,518,667.06 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 38,489,736.44 | 54,407,227.83 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,898,100.00 | 53,360,470.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,532,100.00 | 53,360,470.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,366,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 19,591,636.44 | 1,046,757.83 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,591,636.44 | 00.00 |
| 213304 | Хөрөнгийн | | 0.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-70,395,853.60** | **2,775,671.89** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | -70,395,853.60 | **2,775,671.89** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,179,183,549.00** | **1,360,733,700.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,179,183,549.00** | **1,360,733,700.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 00.00 | 1,164,658,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 1,164,658,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс | 1,029,275,400.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | санхүүжих | | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 6,658,949.00 | 2,812,900.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,500,000.00 | 2,812,900.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 143,249,200.00 | 193,261,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 143,249,200.00 | 193,261,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,179,183,549.00** | **1,333,642,434.43** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,179,183,549.00** | **1,333,642,434.43** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,140,693,812.56** | **1,286,266,196.60** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 796,871,481.40 | 892,239,309.94 |
| 210101 | Үндсэн цалин | 508,776,139.40 | 614,684,852.05 |
| 210102 | Нэмэгдэл | 217,271,152.00 | 235,342,902.28 |
| 210104 | Урамшуулал | 61,151,696.00 | 42,211,555.61 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 9,672,494.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 105,134,800.16 | 110,083,881.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 74,070,345.45 | 72,792,750.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,303,186.23 | 11,428,749.25 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,412,862.67 | 7,030,197.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,485,629.96 | 1,711,753.20 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,862,775.85 | 17,120,431.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 136,170,437.00 | 139,702,688.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,694,756.00 | 5,613,691.00 |
| 210302 | Түлш, халаалт | 132,175,681.00 | 134,088,997.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 13,197,624.00 | 00.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,252,749.00 | 00.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,854,575.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 511,000.00 | 00.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 490,800.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,050,000.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,038,500.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 45,324,070.00 | 55,289,180.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 604,800.00 | 00.00 |
| 210502 | Хоол, хүнс | 42,368,470.00 | 55,289,180.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,350,800.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 36,052,000.00 | 3,726,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 30,200,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,852,000.00 | 3,726,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 928,000.00 | 00.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 928,000.00 | 00.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,955,200.00 | 9,213,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 500,000.00 | 2,812,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 403,200.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,052,000.00 | 6,401,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,060,200.00 | 76,011,237.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 64,074,537.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн даалгага хийх | 5,060,200.00 | 11,936,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **38,489,736.44** | **47,376,237.83** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,898,100.00 | 46,329,480.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 16,532,100.00 | 46,329,480.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,366,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 19,591,636.44 | 1,046,757.83 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,591,636.44 | 00.00 |
| 213304 | Хөрөнгийн | | 0.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** (3)=(1)-(2) | 00.00 | 27,091,265.57 |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 27,091,265.57 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 27,091,265.57 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 448,356,451.20 | 892,668,703.53 | 222,453,169.19 | 1,563,478,323.92 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **448,356,451.20** | **892,668,703.53** | **222,453,169.19** | 1,563,478,323.92 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -70,395,853.60 | -70,395,853.60 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **448,356,451.20** | **892,668,703.53** | 152,057,315.59 | 1,493,082,470.32 |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **448,356,451.20** | **892,668,703.53** | 152,057,315.59 | 1,493,082,470.32 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **448,356,451.20** | **892,668,703.53** | 152,057,315.59 | 1,493,082,470.32 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 2,775,671.89 | 2,775,671.89 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 448,356,451.20 | 892,668,703.53 | 154,832,987.48 | 1,495,858,142.21 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| 2 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 0.00 | (0.00) |
| 21 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,313,788,000.00 | 1,333,642,434.43 | (19,854,434.43) |
| 210 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,313,788,000.00 | 1,333,642,434.43 | (19,854,434.43) |
| 2101 | Бараа, үйлчилгээний зардал | 1,266,905,500.00 | 1,286,266,196.60 | (19,360,696.60) |
| 210101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 857,020,100.00 | 892,239,309.94 | (35,219,209.94) |
| 210102 | Үндсэн цалин | 646,834,500.00 | 614,758,017.05 | 32,076,482.95 |
| 210104 | Нэмэгдэл | 188,216,200.00 | 235,342,902.28 | (47,126,702.28) |
| 2102 | Урамшуулал | 21,969,400.00 | 42,138,390.61 | (20,168,990.61) |
| 210201 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 107,127,400.00 | 110,083,881.66 | (2,956,481.66) |
| 210202 | Тэтгэврийн даатгал | 72,846,700.00 | 72,792,750.31 | 53,949.69 |
| 210203 | Тэтгэмжийн даатгал | 8,570,200.00 | 11,428,749.25 | (2,858,549.25) |
| 210204 | ҮОМШӨ ний даатгал | 6,856,100.00 | 7,030,197.90 | (174,097.90) |
| 210205 | Ажилгүйдлийн даатгал | 1,714,000.00 | 1,761,661.10 | (47,661.10) |
| 2103 | Эрүүл мэндийн даатгал | 17,140,400.00 | 17,070,523.10 | 69,876.90 |
| 210301 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 145,903,100.00 | 139,702,688.00 | 6,200,412.00 |
| 210302 | Гэрэл цахилгаан | 6,150,100.00 | 5,613,691.00 | 536,409.00 |
| 210303 | Түлш, халаалт | 139,453,000.00 | 134,088,997.00 | 5,364,003.00 |
| 2105 | Цэвэр, бохир ус | 300,000.00 | - | 300,000.00 |
| 210502 | Нормативт зардал | 63,423,200.00 | 55,289,180.00 | 8,134,020.00 |
| 2106 | Хоол, хүнс | 63,423,200.00 | 55,289,180.00 | 8,134,020.00 |
| 210604 | Эд хогшил худалдан авах | 3,726,000.00 | 3,726,000.00 | - |
| 2108 | Урсгал засвар | 3,726,000.00 | 3,726,000.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 7,957,800.00 | 9,213,900.00 | (1,256,100.00) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210806 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 2,812,900.00 | (2,812,900.00) |
| 2201 | Мэдээллийн технологийн зардал | 7,957,800.00 | 6,401,000.00 | 1,556,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 81,747,900.00 | 76,011,237.00 | 5,736,663.00 |
| 210902 | Бараа үйлчилгээний бусад зардал | 69,811,200.00 | 64,074,537.00 | 5,736,663.00 |
| | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,936,700.00 | 11,936,700.00 | - |
| 2132 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 46,882,500.00 | 47,376,237.83 | (493,737.83) |
| 261090 | Бусад урсгал шилжүүлэг | 46,882,500.00 | 47,376,237.83 | (493,737.83) |
| 213205 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,046,757.83 | (1,046,757.83) |
| | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг | 46,882,500.00 | 46,329,480.00 | 553,020.00 |
| 1310 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 193,261,900.00 | 1,360,733,700.00 | (1,167,471,800.00) |
| 131001 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | - | 1,164,658,900.00 | (1,164,658,900.00) |
| 1320 | Улсын төсвөөс санхүүжих | - | 1,164,658,900.00 | (1,164,658,900.00) |
| 132001 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 193,261,900.00 | 193,261,900.00 | - |
| 1311 | Орон нутгийн төсвөөс | 193,261,900.00 | 193,261,900.00 | - |
| 131105 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 2,812,900.00 | (2,812,900.00) |
| 0 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 2,812,900.00 | (2,812,900.00) |
| 0 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 0.00 | (0.00) |
| 0 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 27,091,265.57 | (27,091,265.57) |
| 1 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - |
| 610001 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - |
| 63 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | - |
| 620001 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 63.00 | 63.00 | - |
| 620002 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - |
| 620003 | Гүйцэтгэх ажилтан | 47.00 | 47.00 | - |
| 136 | Үйлчлэх ажилтан | 15.00 | 15.00 | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургууль нь багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжиж, хүүхэд хөгжих таатай орчин нөхцлийг бүрдүүлэхэд чиглэн үйл ажиллагаагаа явуулж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Боловсролын тухай хууль - 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрөөс нэмэлт өөрчлөлт оруулсан.
- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьаар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,775.7 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 27,091.3 | 27,091.3 |
| Авлага | 2,081.4 | 327.5 | 0 |
| Бараа материал | 197,725.6 | 214,924.8 | 17,199.2 |
| Үндсэн хөрөнгө | 1,293,275.6 | 1,253,514.6 | -39,761.0 |
| **Нийт хөрөнгө** | **1,493,082.5** | **1,495,858.1** | **2,775.7** |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 448,356.5 | 448,356.5 | -45,012.3 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **1,493,082.5** | **1,495,858.1** | **2,775.7** |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 27,091.3 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн шинэчлэл хэрэгжиж улсын төсвөөс санхүүжиж буй байгууллагуудын дансны үлдэгдлийг татан төвлөрүүлэхгүй байх шийдвэр хэрэгжсэнтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 327,5 мянган төгрөг болж 753.9 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын сангаас авах авлагаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 214,924.8 мянган төгрөг болж 17,199.2 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар ирсэн бараа материалаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,253,514.6 мянган төгрөг болж 39,760.9 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 448,356.5 мянган төгрөг болж 45,012.3 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,360,733.7 мянган төгрөгөөр нийт зарлагыг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвөөс1,164,658.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 19,3261.9 мянган төгрөгөөр тус тус баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,360,733.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,164,658.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 193,261.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,164,658.9 мянга, орон нутгийн төсвөөс 193,261.9 мянга, бусад орлого 2,812.9 мянга, нийт 1,360,733.7 мянган төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаанд 1,333261.9 мянган төгрөгийг зарцуулж орон нутгийн төсөвт 1,046.7 мянган төгрөгийг төвлөрүүлж, улсын төсвийн үлдэгдэл 27,090.3 мянган төгрөг байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | Улсын төсвөөс | 1,164,658.9 | 1,137,568.6 | 27,090.3 | 97.7% |
| | Орон нутгийн төсвөөс | 193,261.9 | 192,215.2 | 1,046.7 | 99.4% |

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,332,596.7 мянган төгрөг буюу 99.0 хувьтай байгаа нь цалин урамшууллын зардлыг 9,134.7 мянга, хоол хүнсний зардлыг 8,134.0 мянга, бараа ажил үйлчилгээний зардлыг 5,7336.6 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Увс Финанс Аудит" ХХК-ийн аудитор Я.Тунгалаг гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Увс Финанс Аудит" ХХК –д 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,252.4 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,398.6 сая төгрөгийн 0.5 хувиар буюу 6.9 сая төгрөгөөр сонгож материаллаг байдлыг 80 хувиар тооцож 5.5 сая төгрөгөөр тогтоож өөрчлөв.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хамаарах зүйл заалтын хүрээнд зөрчил гараагүй байна. /АБ-4/

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаа хоцроож 3, хугацаандаа оруулсан 146 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн тухай хуулийн хэрэгжилт

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургууль нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хяргас сумын Ерөнхий боловсролын сургуулийн хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнэнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

"УВС ФИНАНС АУДИТ" ХХК-ИЙН
АУДИТОР /Я.ТУНГАЛАГ/

2023 оны 02 дугаар сарын 16-ны өдөр